АВЛИГА БА ЖЕНДЭРИЙН АСУУДЛААР СУДАЛГАА ХИЙХ СУДЛААЧИЙН АЖЛЫН ДААЛГАВАР

Байгууллага: Авлигатай тэмцэх газар, Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага
Төсөл: “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал” (2021-2024)
Материал хүлээн авах хугацаа: 2023 оны 5 дугаар сарын 12-ны өдрийн 18.00 цаг
Ажил гүйцэтгэх хугацаа: 7 сар

ОЛОН УЛСЫН ЭРХ ЗҮЙН ХӨГЖЛИЙН БАЙГУУЛЛАГА

Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (ОУЭЗХБ) нь энх тайван, шударга ёс, тогтвортой хөгжлийг дэмжин, эдийн засгийн боломжийг нэмэгдүүлэх, хууль дээдлэх ёсыг бий болгохын төлөө хууль эрх зүйн салбарт шинэчлэл хийх, байгууллагын чадавхыг бэхжүүлэхэд улс орнуудын засгийн газар болон олон нийтийн эрх зүйн ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэн, ажилладаг засгийн газар хоорондын олон улсын байгууллага юм. ОУЭЗХБ-ын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг цахим болон твиттер хуудас (www.idlo.int, Twitter @IDLO)-наас авна уу.

ТӨСЛИЙН ЗОРИЛГО, ЗОРИЛТУУД

ОУЭЗХБ-ын Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газар нь АНУ-ын Засгийн газар Төрийн Департаментын дэргэдэх Олон улсын хар тамхи, мансууруулах бодистой тэмцэх, хууль сахиулах товчооны санхүүжилтээр “Монгол Улсын институцийн шударга, ил тод байдал төсөл”-ийг хэрэгжүүлж байна.

Төслийн хүрээнд Авлигатай тэмцэх газар (АТГ), Улсын ерөнхий прокурорын газар (УЕПГ) болон Олон нийтийн зөвлөлийн чадавхыг бэхжүүлэх, томоохон авлигын хэрэгтэй тэмцэх чиглэлээр холбогдох талуудын хамтын ажиллагаа, зохицуулалт, уялдаа холбоог сайжруулахад олон талт, ажил арга хэмжээг хэрэгжүүлнэ. Төсөл нь гурван бүрэлдэхүүн хэсэгтэй. Үүнд: i) АТГ, УЕПГ болон хууль зүйн салбарын холбогдох байгууллагын авлигын хэргийг мөрдөх үр чадварыг нэмэгдүүлсэн байна; ii) Авлигаас урьдчилан сэргийлэх иргэний хяналтыг сайжруулсан байна; iii) Авлигын эсрэг НҮБ-ын конвенцын хэрэгжилт, АТГ-ын Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөрийг боловсруулахад дэмжлэг үзүүлсэн байна. Төслийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг https://bit.ly/3sOz22O холбоосноос авна уу.

ЗӨВЛӨХИЙН АЖЛЫН ХҮРЭЭ, ДААЛГАВАР

Зөвлөх нь ажлын даалгаврын дагуу авлига ба жендэрийн хамаарлыг харуулсан судалгааны авлигын асуудлыг хариуцан судална. Энэ чиглэлээр хийгдсэн ижил төстэй дотоод, гадаадын судалгаа, баримт бичиг, мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийнэ. Төслийн гол хамтрагч болох АТГ-ын Судалгаа, шинжилгээний алба болон ОУЭЗХБ-ын Хөтөлбөрийн менежертэй зөвшилцөн судалгааны хүрээ, арга зүй, асуумжийг боловсруулна. Жендэрийн зөвлөхтэй нягт хамтран ажиллана. АТГ-ын Судалгаа, шинжилгээний албатай хамтран уулзалт, хэлэлцүүлэг хийх, мэдээлэл цуглуулах, судалгааны тайлан боловсруулах ажлуудыг гүйцэтгэнэ. Хөтөлбөрийн менежер, Суурин төлөөлөгчийн удирдлага дор дараах үндсэн ажлыг гүйцэтгэнэ.

- Авлига ба жендэрийн чиглэлээр хийгдсэн дотоод, гадаадын судалгаа, баримт бичгийн судалгаа хийх, дүн шинжилгээ хийх;

- Ажлын төлөвлөгөө, урьдчилан судалсан мэдээлэлд хийсэн судалгааны дүн, судалгааны хүрээ, арга зүйг санал болгосон эхлэлтийн тайланг хүргүүлэх;
- Жендэрийн зөвлөхтэй зөвшилцөн судалгааны хүрээ, арга зүй, судалгааны асуумжийг боловсруулан, АТГ, ОУЭЗХБ-аас санал аван, эцэслэх;
- АТГ-ын Судалгаа шинжилгээний албатай нягт хамтран ажиллаж, саналыг тухай бүр тусгах;
- Жендэрийн зөвлөхтэй хамтран судалгааны тайланг боловсруулж, хугацаанд нь хүргүүлэх;
- Судалгааны үр дүнг танилцуулах уулзалт, хэлэлцүүлэгт оролцох;
- Гүйцэтгэлийн тайланг Монгол хэл дээр боловсруулж хүргүүлнэ.

СУДЛААЧИД ТАВИГДАХ ШААРДЛАГА

Судлаач нь дараах ур чадварыг эзэмшсэн байна:

- Нийгмийн ухаан, социологи, эрх зүй, болон холбогдох чиглэлээр магистрын зэрэгтэй, докторын зэрэгтэй бол давуу тал болно;
- Авлигын чиглэлээр судалгаа, үнэлгээний ажил хийсэн бол давуу тал болно;
- Чанарын болон тоон судалгааны арга зүйг эзэмшсэн байх;
- Монгол хэлний өндөр мэдлэгтэй байх;
- Англи хэлний дундаас дээш түвшний мэдлэгтэй бол давуу тал болно;
- Багаар ажиллах чадвартай, харилцааны өндөр соёлтой байх.

АЖЛЫН ДААЛГАВАР, ТАВИГДАХ ШААРДЛАГА

2023 оны 5 дугаар сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 31-ны өдөр хүртэл хугацаанд ажиллана. Хүснэгт 1-д үндсэн ажлуудаас сонгон тайлант хугацаанд хүргүүлэх ажлыг тоймлон харуулав:

Хүснэгт 1: Тайланд тавигдах шаардлага

№	Тайлан, Бүтээгдэхүүн	Төлбөр	Хугацаа
1	Ажлын календарчилсан төлөвлөгөө, урьдчилан судалсан мэдээлэл, судалгааны хүрээ, арга зүйг санал болгосон эхлэлтийн тайланг хүргүүлэх	2,400,000	2023 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн дотор хүргүүлснээр гэрээний 30 хувийн төлбөрийг төлнө.
2	Судалгааны тайлангийн эхний төслийг Монгол, Англи хэл дээр хүргүүлэх	-	2023 оны 9 дугаар сарын 31
3	Судалгааны тайланг Монгол, Англи хэл дээр эцэслэн, холбогдох байгууллага, ОУЭЗХБ-д хүлээлгэн өгөх	3,200,000	2023 оны 10 дугаар сарын 31
4	Гүйцэтгэлийн тайланг Монгол хэл дээр боловсруулж, хүргүүлэх	2,400,000	2023 оны 12 дугаар сарын 10
		8,000,000	100%

Дээрх ажлын гүйцэтгэл, чанар, хугацаанд нь хэрэгжүүлсэн, болон Хөтөлбөрийн Менежерийн хүлээн авсныг үндэслэн зөвлөх үйлчилгээний төлбөрийг олгоно. Хөтөлбөрийн менежер төлбөрийн хүсэлтийг батална. Нэхэмжлэх ирүүлснээс хойш 30 хоногийн дотор төлбөрийг шилжүүлнэ.

ОУЭЗХБ нь төсөл хэрэгжүүлэх явцад тулгарч болзошгүй аливаа эрсдэлээс сэргийлэх зорилгоор бүх талуудтай зөвлөлдсөний үндсэн дээр Ажлын удирдамжид өөрчлөлт оруулах эрхтэй.

ОУЭЗХБ нь ажил олгогчдод тэгш боломжоор хангах бодлогыг баримталдаг бөгөөд байгууллагын бүхий л үйл ажиллагаанд нийцүүлэн хэрэгжүүлдэг.

БҮРДҮҮЛЭХ БАРИМТ БИЧИГ

Сонирхсон ажил горилогч товч намтар (CV), сонирхлоо илэрхийлсэн захидал (Cover letter), дипломын хуулбар, ижил төстэй хийсэн ажлын тодорхойлох захидлын хамт **ubyambaa@idlo.int** цахим хаягт **2023 оны 5 дугаар сарын 12-ны** дотор илгээнэ үү.